

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2000 оны 12 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

Үнэт цаасны арилжааны хугацаанд  
өөрчлөлт оруулах тухай

Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Монголын хөрөнгийн биржээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. 2000 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 7 хоногийн Бямба, Ням гаригаас бусад өдөр, өдөр бүрийн 11.00 цагаас 12.00 хүртэлх хугацаанд Монголын хөрөнгийн биржид үнэт цаасны арилжааг төвлөрүүлэн явуулж байхаар тогтоосугай.

2. Үнэт цаасны арилжааны хугацаанд өөрчлөлт орсонтой холбогдуулан Хорооны 1996 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 26 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.ГҮНДЭНБАЛ